



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 23 өдөр

Дугаар А/369

Мяндалговь

Бруцеллёзын вакцинжуулалт,
шинжилгээний ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалт, Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.1, "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн 3.3.1.3 дахь заалт, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг үржлийн газрын даргын 2017 оны 06 сарын 23 өдрийн А/30 дугаар тушаалыг үндэслэн тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Бруцеллёзын шинжилгээний ажлын удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах малын тоо, шаардагдах вакцины хуваарийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Хоёр. Мал сүргийг бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх өргөн вакцинжуулалтад хамруулах, богийн хээлтүүлэгч малд бруцеллёзын шинжилгээ хийх ажлыг бүх сумдад 10 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд багтаж зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Вакцинжуулалтын ажлыг мэргэжил арга зүйн зөвлөмжөөр ханган ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хүнс хөдөө аж ахуйн газар /Б.Мөнхжаргал/, Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0201008

